

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

2023.07.04

Алтай хот

Дараах машинуудыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 37 дүгээр тогтоолын дагуу дахин дуудлага худалдаагаар худалдах тул иргэд та бүхнийг дуудлагын худалдаанд өргөнөөр оролцохыг урьж байна.

Үүнд:

№	Хөрөнгийн нэр, төрөл	Үйлдвэр-лэсэн огноо	Ашиглалтанд орсон огноо	Ашигласан жил	Дуудах доод үнэ /төгрөг/
Нэг. Автомашин					
1.1	Бугат сумын ЗДТГ, УАЗ хантер ГАА88-48	2018	2019	5	12,300,000
1.2	Тонхил сумын Эрүүл мэндийн төв, УАЗ 31512 ГАУ70-88	2013	2013	10	3,125,000

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ: Үүнд:

- Иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна/.
 - Дуудлагын худалдаанд орох хүсэлт /Батлагдсан маягтыг бөглөх/
 - Дэнчин тухайн хөрөнгийн дуудах доод үнийн 25% байх бөгөөд дэнчинг байгууллагын "Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн 100050051424" тоот дансанд тушааж, баримтыг материалд хавсаргана.
- Дуудлагын худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд дээрх бичиг баримтыг бүрдүүлэн дугтуйд хийж битүүмжлээд, дугтуйны гадна талд худалдан авах хөрөнгийн нэр, төрлийг бичсэн байна.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ГАРГАХ:

- Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтээ аймгийн Нутгийн удирдлагын ордонд байрлах Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнд байрлуулсан лацтай хайрцагт зар гарсан өдрөөс эхлэн 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 18:00 цагаас өмнө хийсэн байна.
- Дуудлагын худалдааг 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 10:00 цагт Говь-Алтай аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгуулна.
- Худалдан авах хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнөөс авна уу.

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Нээлттэй дуудлагын худалдаанд зарлагдсан хөрөнгийг дуудлага худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд хөрөнгийг өөрийн биеэр сайтар үзэж танилцан, сонголтоо хийнэ үү.
- Дуудлагын худалдаа зарласан цагтаа эхлэх тул оролцогч иргэд, хуулийн этгээд та бүхэн хугацаа хоцрохгүй байхыг анхааруулж байна.

Жич: Төрийн сангийн гүйлгээ цахимаар хийгдэж байгаа тул дэнчингийн мөнгийг буцааж авах иргэд Татварын удирдлагын нэгдсэн системд харилцах дансаа заавал бүртгүүлсэн байх шаардлагатай. Гүйлгээг ажлын 3 хоногт багтаан хийгдэнэ.

/Бугат сумын УАЗ хантер ГАА88-48 дугаартай автомашин Бугат суманд байгаа. Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн УАЗ 31512 ГАУ70-88 дугаартай автомашин Тонхил суманд байгаа/

ЛАВЛАХ УТАС: 70483302

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР